



Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газар

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ НЬ
ШААРДЛАГА ХАНГААГҮЙГЭЭС ТӨСӨЛ, АРГА
ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮНД
НӨЛӨӨЛЖ БАЙНА**

2023 оны 4 дүгээр сар

**УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: ДГА-2023/28-8-ШТА-ГА

АГУУЛГА:

Товьёг	2
Товчилсон үгийн тайлбар	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4

Бүлэг 1: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг монгол улсын хөгжлийн бодлогын баримт бичиг болон хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлоготой уялдуулан төлөвлөөгүй байна

А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.....7

А.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна.....8

Бүлэг 2: Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зарим үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байна

Б.1 Худалдан авах ажиллагаа нь холбогдох хуулийн дагуу зохион байгуулагдсан байна 10 |

Б.2 Тайлант онд батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл бүрэн дуусаагүй байна 12 |

Б.3 Санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэлийг бүрэн хянаагүй байна 17 |

Б.4 Барилгын ажлын үе шатны болон гүйцэтгэлд хяналт тавих ажил хангалтгүй байна.....18

Б.5 Тайлант онд дуусаж, хүлээн авсан төсөл арга хэмжээ нь хууль тогтоомжид заасан шаардлага, нөхцөлийг хангаагүй байна.....19

Бүлэг 3: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зарим ажил үр дүнгүй байна

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна.....20

В.2. Зарим төсөл, арга хэмжээ нь ажил ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна.....24

Холбогдох байгууллагын санал:

Санал өгсөн тайлбар:

Дүгнэлт:

Зөвлөмж:

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн шийдвэр	10
Хүснэгт 2	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалт	16
Хүснэгт 3	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ	21
Хүснэгт 4	Замын-Үүд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн байгууллагуудад үзүүлсэн дэмжлэгийн жагсаалт	22
Хүснэгт 5	Орон нутгийн төсвийн тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ	23
Хүснэгт 6	Аймагт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гүйцэтгэж байгаа ААНБ-ын мэдээлэл	25
Хүснэгт 7	Дорноговь аймагт хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл	30

Зургийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Мандах сумын тохижилтыг ажил	12
Зураг 2	Цэвэр усны нөөц сан	13
Зураг 3	Даланжаргалан сумын 15 ортой эрүүл мэндийн төв	13
Зураг 4	Хүүхдийн зуслангийн барилга, байгууламж	14
Зураг 5	Монгол соёл- Монгол хүмүүн	14
Зураг 6	Сайншанд сумын “50 ортой төрөх эмнэлэг”	15
Зураг 7	Замын-Үүд сумын “Соёл спортын цогцолбор”	15
Зураг 8	Өргөн сумын Ахмадын өргөөний барилга	26
Зураг 9	Сайншанд, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт нийлүүлсэн бүрэн тоноглолтой автомашин	26
Зураг 10	Эрдэн сумын төрийн албан хаагчийн байр	27
Зураг 11	Хамарын хийдийн захиргаанд нийлүүлсэн усны машин	27
Зураг 12-13	Хүүхдийн зуслангийн тавилга, тоног төхөөрөмж	27
Зураг 14	Халдвартын эмнэлгийн тавилга, тоног төхөөрөмж	28
Зураг 15	Тохжилт Сайншанд хот тохижилтын газарт нийлүүлсэн хогийн автомашин	28
Зураг 16	Сайншанд сумын автозамд нийтийн тээврийн автобусны зогсоол	29
Зураг 17	Сайншанд сумын төвийн автозамд тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, хучлагын засвар	29
Зураг 18	Мод усалгааны автомашин	29
Зураг 19	Үрслэгээний хөрсөн бортого	30

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаа	11

Товчилсон үгийн тайлбар

Товчилсон үг	Тайлбар
ААНБ	Аж ахуй нэгж, байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГИХГ	Гадаадын иргэн, харьяатын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗТХС	Зам тээвэр, хөгжлийн сайд
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХА	Харьцуулалтын арга
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/04 дугаар тушаалаар батлагдсан “Аудитын жилийн төлөвлөгөө”-ний дагуу хийж гүйцэтгэв.
Аудитын зорилт	Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх; - Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх; - Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр баталсан 162 төсөл, арга хэмжээний төлөвлөлт, судалгаа, тайлан, арга хэмжээний зураг төсөл, ХАА-ны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, санхүүжилт, гэрээний хэрэгжилт, хяналт шалгалтын баримтад үндэслэн аудитыг хийж гүйцэтгэв. Аудитаар аймгийн ТЭЗ, аймаг, сумдын ЗДТГ, ГХБХБГ, ОНӨГ, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч гүйцэтгэгч байгууллага, холбогдох албан тушаалтнуудыг хамрууллаа.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”, MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийж журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”-ын дагуу аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, иргэн, ААНБ-ын үйл ажиллагаатай танилцах, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, аудитын менежер У.Оюунтүлхүүр аудитын стандарт, арга зүйн дагуу хяналт тавьж, ахлах аудитор Л.Равдандорж, аудитор Б.Уранбилэг нар хийж гүйцэтгэв. Аудитыг 2023 оны 02 дугаар сарын 27-нд эхэлж, 4 дугаар сарын 20-ны өдрийн дотор хийж гүйцэтгэнэ. Аудитын тайланг ҮАГ болон бусад холбогдох газар, албан тушаалтанд хүргүүлэв.
Хүндрэл бэрхшээл	Аудитын явцад аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс аудитад шаардлагатай баримтыг албан бичигт дурдсан хугацаанд ирүүлдэггүй, удаа дараа шаардуулдаг, хариуцсан албан тушаалтан тайлбар тодруулга өгдөггүй байдал нь аудитыг хийж гүйцэтгэхэд хүндрэлтэй байв.
Ерөнхий мэдээлэл	Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус аймагт 81,115.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас 61,729.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнээс 12 төсөл, арга хэмжээ нь шинээр, 3 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжиж ирсэн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 98,856.9 сая төгрөгийн 147 төсөл, арга хэмжээ батлагдсанаас шинээр хэрэгжих 24,423.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс аймгийн хөрөнгө оруулалтад 22,105.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 төсөл, арга хэмжээ, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар 2,318.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээ, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 57,561.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээнд 23,734.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тус тус баталсан. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлсэн нийт 138 төсөл, арга хэмжээнд 30,819.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

БҮЛЭГ 1: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НЭГДСЭН БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛАН ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА

А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдаагүй байна.

А.1.1 Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй ерөнхий утгаар нийцэж байна

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Дорноговь аймагт нийт 81,115.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлж, санхүүжүүлэхээр батлагдсан. Үүнээс 61,729.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээний эрхийг орон нутагт шилжүүлсэн байна.

Дээрх батлагдсан төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050 урт хугацааны бодлого”-ын баримт бичигт нийцсэн байна.

А.1.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын 2021-2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдаагүй байна

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг баталж, хоёрдугаар хавсралтаар “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг баталжээ.

Дорноговь аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ нь дээрх баримт бичигт тусгагдаагүй байна. Харин “Дорноговь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон аймгийн Засаг даргын “Хөгжлийн төлөө хамтдаа-2” үйл ажиллагааны хөтөлбөрт бүрэн тусгагдсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутагт хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан ч Монгол Улсын дунд хугацааны бодлогын баримт бичигтэй бүрэн уялдаагүй байна.

А.1.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь хөгжлийн бодлогын баримт бичгийн уялдааг бүрэн хангаагүй ч нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, иргэдийн амьдралд эерэг өөрчлөлтийг бий болгохуйц хөрөнгө оруулалт хийгдэж байна

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чанараар Азид тэргүүлэгч орнуудыг нэг болно гэж тодорхойлсон.

Мөн 2020 онд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль шинэчлэн батлагдсан. Энэхүү хуульд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, удирдлага зохион байгуулалт зэрэг хөгжлийн бодлогын баримт бичгийн эрх зүйн орчны талаарх

зохицуулалтыг бий болгосон. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6¹, 4.1.7², 4.1.10³, 4.1.12⁴-д хөгжлийн бодлогын баримт бичиг, тэдгээрийн хоорондын уялдааг хангасан байхаар хуульчилсан.

Мөн хуулийн 5.2.12-т "..., төлөвлөлтийн дээрээс доош төлөвлөх буюу нэгдсэн зорилго зорилтыг дэвшүүлж салбар болон бүс нутгуудад хэрэгжүүлэх" гэж заасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан нийт арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацаа хөгжлийн бодлогын баримт бичигтэй ерөнхий утгаар, дунд хугацааны бодлогын баримт бичигт бүрэн тусгагдаагүй⁵, орон нутагт хэрэгжүүлэх дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зэрэг нь хөгжлийн бодлогын баримт хоорондын уялдааг хангаагүй, дээрээс доош төлөвлөх нэгдсэн зорилго зорилттой бүрэн нийцээгүй байна.

Хэдийгээр хуульд заасан бодлогын баримт бичгийн уялдаа алдагдсан ч хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ нь зорилтот бүлэгт шаардлагатай, олон нийтийн хэрэгцээг хангахуйц гэж дүгнэж байна.

А.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна

А.2.1 Орон нутгийн өмчлөлд шилжих боломжтой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийг зарлага" гэж тодорхойлсон.

Тайлант онд эрх шилжсэн, шинээр барилга байгууламж барих 10 төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмж худалдан авах 2 төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн. Эдгээр нь орон нутгийн өмчлөлд шилжих боломжтой байна.

А.2.2 Улсын төсвөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох журамд заасны дагуу төлөвлөөгүй байна

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-т Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг хэрхэн төсвийн төсөлд тусгуулах, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах" журмын 3 дахь хэсгийн 3.1.4⁶-т Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн саналыг ирүүлэхдээ хангах шалгуур үзүүлэлтийг заасан.

¹ "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт нийцүүлсэн улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн уялдааг хангасан зорилго, зорилт, хүрэх үр дүн, нөөцөд суурилан боловсруулсан төсөл, арга хэмжээг агуулсан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт бүхий дунд хугацааны нэгдсэн төлөвлөлтийн баримт бичгийг;

² "Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг;

³ "Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэхэд чиглэсэн төлөвлөлтийн баримт бичгийг;

⁴ "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр" гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн хавсралт баримт бичгийг;

⁵ Боловсролын ерөнхий утга агуулсан.

⁶ 3.1.4.1.бодлогын баримт бичигт тусгагдсан байдал

3.1.4.2.хөгжлийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй нийцэж буй байдал;

3.1.4.3.хэрэгцээ шаардлага, үндэслэл;

3.1.4.4.мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

3.1.4.5.төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;

Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус аймагт 81,115.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсанаас 61,729.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнээс 12 төсөл, арга хэмжээ нь шинээр, 3 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжиж ирсэн байна.

Мөн дээрх журмын 2 дахь хэсгийн 2.1.2-т төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж хөрөнгө оруулалтын төслийн саналыг судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх, үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог гаргах зэрэг ажлуудыг хийх үүргийг тусгасан.

Гэтэл 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн саналын төлөвлөлтөд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ээс журамд заагдсан үүрэг бүхий ажлууд нь хийгдээгүй байна.

Иймд дээрх зөрчилд холбогдох албан тушаалтанд хариуцлагын арга хэмжээ авах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

А.2.3 Шинээр хэрэгжүүлсэн 4 төсөл, арга хэмжээний зураг төслийг төсөв батлагдсанаас хойш боловсруулж, баталсан байна

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасан.

Тайлант хугацаанд орон нутагт эрх шилжсэн 12 төсөл, арга хэмжээ нь барилга байгууламж шинээр барих ажил байна. Үүний 4 төсөл, арга хэмжээний зураг төсөв 2022 оны 2-3 сард буюу төсөв батлагдсанаас хойш батлуулсан, 1 төсөл, арга хэмжээ нь техникийн нөхцөл аваагүй байна. Үүнд:

- Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн барилгыг буулгаж шинээр барих ажил - (2,572.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй) 2022 оны 02 дугаар сард боловсруулагдсан.
- Сумын тохижилтын ажил-Мандах сум - (200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй). 2022 оны 02 дугаар сард боловсруулагдсан.
- Сургуулийн барилга, 320 суудал /Дорноговь, Хатанбулаг сум, 5 дугаар баг/ - (7,898.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй). 2022 оны 03 дугаар сард боловсруулагдсан.
- Сургуулийн барилга, 640 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/ - (9,465.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй). 2022 оны 01 дүгээр сард боловсруулагдсан.
- “Мандах сумын тохижилт” – (200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй). Газрын зөвшөөрөлгүй, цахилгааны нөхцөл олгогдоогүй байна.

А.2.4 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4-т “... Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байна”, 29¹.2.4-т төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь “урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх” гэж заасан.

3.1.4.6.санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл.

Тайлант онд хэрэгжүүлэхээр хуулиар батлагдсан нийт төсөл, арга хэмжээний ашиглалттай холбоотой урсгал зардлыг тооцоогүй, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлт гараагүй, санал хүргүүлэх жагсаалтаас өөр баримт материал байхгүй байна.

А.2.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан зарим заалт 2022 оны хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хамаарахгүй байна

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1, 13.1.2 дахь заалт нь 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх, 13.3, 13.4 дэх хэсэг нь улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн 2023 оны төсвийн жилээс эхлэн шинээр тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хамаарахаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.2 дахь хэсэгт заасан байна.

Мөн 2022 оны улсын төсвөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд 13 дугаар зүйлийн 13.1.3-13.1.7 дахь заалтыг зөрчсөн асуудал байхгүй байна.

БҮЛЭГ 2: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ЗӨРЧСӨН БАЙНА

Б.1 Худалдан авах ажиллагаа нь холбогдох хуулийн дагуу зохион байгуулагдсан байна

Б.1.1 Нийт 100.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээг тайлант хугацаанд хэрэгжих боломжгүй хугацаанд эрх шилжүүлсэн байна

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т заасны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 44,560.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг эрхийг шилжүүлсэн байна. /Хүснэгт №1/

Хөрөнгө оруулалтын эрх шилжүүлсэн шийдвэр

/Хүснэгт №1/

№	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төгрөг/	Эрх шилжүүлсэн шийдвэр
1	БХБС	Сумын тохижилт /Дорноговь, Мандах сум/	200.0	БХБС-ын 2021.12.10 өдрийн 267-р тушаал
2	ХНХС	Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын барилгыг буулгаж, шинээр барих /Дорноговь, Сайншанд сум/	2,572.8	Засгийн газрын 2022 оны 61-р тогтоол
3	БХБС	Цэвэр усны нөөц сан /Дорноговь/	2,000.0	БХБС-ын 2021.12.10 өдрийн 267-р тушаал
4	БШУС	Сургуулийн барилга, 320 суудал /Дорноговь, Хатанбулаг сум, 5 дугаар баг/	7,898.3	БШУС-ын 2021.12.08 А/430-р тушаал
5	БШУС	Сургуулийн барилга, 640 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/	9,465.9	БШУС-ын 2021.12.08 А/430-р тушаал
6	ЗТХС	Сайншанд-Замын-Үүд чиглэлийн авто замаас Өргөн сум хүртэлх хатуу хучилттай авто замын үргэлжлэл /Дорноговь, Сайншанд сум/	3,700.0	ЗТХС-ын 2021.12.07 А/186-р тушаал
7	ЭМС	Эрүүл мэндийн төвийн барилга, 15 ор /Дорноговь, Даланжаргалан сум/	1,650.0	ЭМС-ын 2022.02.22 А/101-р тушаал
8	СоС	Саран хөхөө театрын барилга, 700 суудал /Дорноговь, Сайншанд сум, 7 дугаар баг/	16,806.1	шийдвэр гараагүй
9	БОАЖС	Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг /Улсын хэмжээнд/	100.0	БОАЖА-ны 2022.02.14 А/29-р тушаал
10	ХХААХҮС	"Малын тэжээлийн нөөц бүрдүүлэх тоног төхөөрөмж"- Мандах сум	50.0	ХХААХҮС-ын 2022.10.12 А/319-р тушаал

11	ХХААХҮС	"Малын тэжээлийн нөөц бүрдүүлэх тоног төхөөрөмж"- Сайхандулаан сум	50.0	ХХААХҮС-ын 2022.10.12 А/319-р тушаал
12	БОАЖС	Дорноговь аймгийн Сайншанд суманд 8 га хамгаалалтын ойн зурвас байгуулах	67.4	БОАЖА-ны 2022.02.10 А/28-р тушаал
Нийт дүн			44,560.5	

ХХААХҮС-ийн 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/319 дүгээр тушаалаар нийт 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний ("Малын тэжээлийн нөөц бүрдүүлэх тоног төхөөрөмж"- Мандах сум 50.0 сая төгрөгийн төсөвт өртөг, "Малын тэжээлийн нөөц бүрдүүлэх тоног төхөөрөмж"- Сайхандулаан сум-50.0 сая төгрөгийн төсөвт өртөг)-ний эрх шилжүүлсэн байна. Эрх шилжүүлэх шийдвэр нь оройтсоноос шалтгаалан худалдан авах ажиллагааг 2022 оны 11 дүгээр сард зохион байгуулж, ажил гүйцэтгэх гэрээний хугацааг он дамжин хэрэгжүүлэхээр тусгажээ.

Б.1.2 Тендерийн баримт бичгийг жишиг загварын дагуу боловсруулж, батлуулсан байна

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 12 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороог байгуулж, тендерийн баримт бичгийг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 19.1⁷, 19.2⁸-д заасны дагуу боловсруулсан байна.

Б.1.3 Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.1⁹-д зааснаар аймгийн Засаг даргын захирамжаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хэрэгжүүлэх 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулсан байна.

Тайлант онд эрх нь шилжин ирсэн 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны 70 хувь нь НТШ, 30 хувь нь ХА-аар зохион байгуулагдсан байна. Энэ нь дээрх хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1¹⁰, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ"-ийг баримталсан байна. /График №1/



Нийт 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа зарлагдсанаас 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Аялал жуулчлалын байгаль, түүх, соёлын өв бүхий

⁷ Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ

⁸ Тендерийн баримт бичигт тендер оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендер оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана.

⁹ Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна.

¹⁰ 8.1.1.харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

8.1.2.шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

8.1.3.зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

газруудад ариун цэврийн газар, авто зогсоол бүхий отоглох цэг” ажлын тендерт оролцогч ирээгүй шалтгаанаар хүчингүй болсон байна.

Мөн 2021 онд “Саран хөхөө театрын барилга”-ын ажлын тендерийг 9,500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зарласан. Гэтэл магадлалын дүгнэлтээр 16,806.1 сая төгрөгөөр батлагдсан байна. Төсөвт өртгийн зөрүү болох 7,306.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх тендерийг 2022 онд дахин зохион байгуулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хууль болон Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам-д заасны дагуу 2022 оны худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, нээлттэй, ил тод байдлыг хангаж ажилласан байна.

Б.2 Тайлант онд батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл бүрэн дуусаагүй байна

Б.2.1 Бүрэн хэрэгжсэн төсөл, арга хэмжээ нь батлагдсан зураг төсвийн дагуу хийгдээгүй, дуусаагүй байна

Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-д барилга байгууламж нь “зураг төслийн дагуу баригдсан байх” гэж заасан.

Гэтэл дараах төсөл, арга хэмжээ батлагдсан зураг төсвийн дагуу хийгдээгүй байна. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд гүйцэтгүүлж, хүлээн авсан Мандах сумын тохижилтыг ажил нь батлагдсан зураг төсвийн дагуу хийгдээгүй, бодит ажлын гүйцэтгэл дутуу байна. /Зураг №1/



Батлагдсан зураг төсөл /харагдах байдал/



Бодит байдал-Сагсан бөмбөгийн талбай



Бодит байдал-Хүүхдийн тоглоомын талбай



Бодит байдал-цамхагт гэрэлтүүлэг, дүрс ажиглалтын систем

Дээрх хүлээн авсан ажлыг батлагдсан зураг төсөвтэй харьцуулахад сагсан бөмбөгийн талбайн гадаргууд бетон цутгасан, зориулалтын будгаар будаагүй, талбайд байршуулсан

шал бэхлээгүй, сагсны шит суурилуулаагүй нүх ухаж орхисон, ор төмөр торон хашаа байршуулсан ч гол рамтай бүслүүрдэж гагнаагүй байна. Тоглоомын талбайн ажил: Төмөр хашааг өнгийн будгаар алаглуулж будаагүй, илүү гарсан төмрийг тайраагүй үзүүртэй, сүүдрэвчийн дээврийн OSB хавтанг будаагүй, дээврийн баганын холбоосыг нэмэлт анкераар бэхлээгүй байна. Гэрэлтүүлгийн ажил: 6 толгойтой 6 ширхэг цамхагт гэрэлтүүлэг усрахаас 2 шон суурилуулсан ч кабелын утас доош сул унжсан, 4 шонг суурилуулаагүй нүх ухаж орхисон, шонгийн суурийн бетон цутгаагүй, анкерлаж бэхлээгүй шонд хяналтын камерыг бүрэн суурилуулаагүй, тохируулга хийгдээгүй зэрэг зураг төсөвт тусгагдсан ажлууд хийгдээгүй байна.

- Тайлант онд ажлын гүйцэтгэлээр хэрэгжиж дууссан 1,983.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Цэвэр усны нөөц сан” төсөл, арга хэмжээний зураг төсөв, ажлын графикт тусгагдсан ажил одоог хүртэл дуусаагүй, туршилт, тохируулгын ажил хийгдээгүй, гэрээний хугацаа дууссан байна. Аудитын явцад усны нөөцийн сангийн дотор ханыг зориулалтын будгаар будах ажил хийгдэж байна. /Зураг №2/



Зураг № 2

Усан санд одоогийн байдлаар хийгдэж байгаа ажлын явц

Дээрх барилга угсралтын ажлын гүйцэтгэлээр хэрэгжүүлж дууссан гэх 2 төсөл, арга хэмжээ нь батлагдсан зураг төсвийн дагуу хийгдээгүй, одоог хүртэл дуусаагүй байна.

- Мөн 1,648.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Даланжаргалан сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилгын ажил нь барилгын зураг төсөв, ажлын тоо хэмжээний дагуу хийгдээгүй байна. /Зураг №3/



Зураг № 3

Дотор талын хана барьсан байдал



Барилгын төмөрбетон каркасын зарим бүтээцийн цутгалтын үед доргиур дутуу хэрэглэснээс гадна, дотор хана, тааз, шаланд сийрэгжилт үүссэн

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн 1,589.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хүүхдийн зуслан”-ийн ажлыг 2022 онд улсын комисс хүлээж авсан ч ашиглалтын шаардлага хангаагүй байна. Тухайлбал: барилгын үндсэн хийцэд зай, завсар их байгаагаас зуслангийн бүх барилгад тоос шороо ихээр орж, халуун усны барилгын тааз нурсан, гаднах сүүдрэвчний дээвэр бороонд норж эвдэрсэн, хүүхдийн биеийн тамирын талбайд хагарал үүссэнээс шалтгаалж хүүхэд бэртэх эрсдэлтэй байдал үүссэн байна. /Зураг №4/

Зураг № 4



Хүүхдийн зуслангийн барилга, байгууламж, зам, талбай, гаднах тохижилтод үүссэн эвдрэл, гэмтэл

Тус зөрчилд барилгын норм дүрэм, стандартын дагуу гүйцэтгүүлэх, зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

- Мөн өмнөх оны аудитаар “Монгол соёл- Монгол хүмүүн” төслийн хүрээнд 8 суманд чанаргүй хэрэгжүүлсэн арга хэмжээг дахин хийлгүүлэх албан шаардлага өгсөн боловч өнөөдрийг хүртэл тодорхой арга хэмжээ аваагүй байна. Тухайлбал: ТББ-т тусгагдсан ажлын тоо, хэмжээнээс зөрүүтэй, дутуу, чанарын шаардлага хангаахааргүй хөрөнгө, засвар, үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 180.8 сая төгрөгийн сургалтын зардлыг бусад хөрөнгөд зарцуулах гэх мэт. /Зураг №5/

Зураг № 5



Монгол соёл-Монгол хүмүүн төслийн хүрээнд нийлүүлэгдсэн хэрэгцээ, шаардлагад нийцээгүй хөрөнгө

Тус зөрчилд өмнөх онд албан шаардлага хүргүүлсэн боловч хэрэгжүүлээгүй тул хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.2.2 Тайлант хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар их засварын ажил хийгдээгүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлсэн 12 төсөл, арга хэмжээ, шилжих 3 төсөл, арга хэмжээ байгаагаас барилга байгууламж шинээр барих 13 төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмж худалдан авах 2 төсөл, арга хэмжээ байна. Их засварын ажил батлагдаагүй байна.

Б.2.3 Техникийн тодорхойлолтод тусгасны дагуу тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна

Тайлант онд нийт 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй малын тэжээлийн нөөц бэлтгэх 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтод заасны дагуу хүлээн авсан байна.

Б.2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “ТЭЗҮ” төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрх шилжээгүй байна

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар Дорноговь аймагт “ТЭЗҮ” ангилалд 4 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан ч холбогдох сайд нараас эрх шилжүүлээгүй байна.

Б.2.5 Улсын төсвийн хөрөнгөөр 2011-2013 онд хэрэгжүүлж эхэлсэн 2 төсөл, арга хэмжээ орхигдсон байна.

Тус аймагт 2022 оны байдлаар 1,285.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2011 онд Сайншанд суманд хэрэгжиж эхэлсэн “50 ортой төрөх эмнэлэг”-ийн барилгын ажил, 5,844.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2013 онд Замын-Үүд суманд хэрэгжиж эхэлсэн “Соёл спортын цогцолбор”-ийн барилгын ажлууд дуусаагүй, орхигдсон байна. Эдгээр нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Сайншанд сумын “50 ортой төрөх эмнэлэг”-ийн барилгын ажил: Улсын төсвийн хөрөнгөөр 2011 онд 1,285.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан. Тус барилгын ажлыг гүйцэтгэхээр “Мон инж бар” ХХК шалгарч, ЭМЯ-аас санхүүжилтийг бүрэн олгосон байна. Барилга угсралтын явцад 2013 онд БНБД-ийг ноцтой зөрчсөн нь илэрч холбогдох зарим арга хэмжээг авсан боловч 2014 оноос төсвийн норм дүрэм шинэчлэгдсэн, бараа материалын үнэ өссөн зэрэг шалтгаанаар зогссон байна. Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн нэхэмжлэлтэй шүүхэд шилжсэн боловч одоог хүртэл шийдэгдээгүй байна.
2. Замын-Үүд сумын “Соёл спортын цогцолбор”-ын барилгын ажил: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2013 онд 5,844.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан. Тус барилгын ажлыг гүйцэтгэхээр “Фронт гейт” ХХК шалгарч, захиалагчийн хяналтыг БХТ-өөс хэрэгжүүлж, 2,749.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Барилга угсралтын явцад гал гарч зарим ажлыг шинэчлэн хийгээд, 2015 оноос барилгын ажил зогссон байна. Аймгийн Засаг даргаас 2017 онд төрд учруулсан хохирлыг төлүүлэхээр Цагдаагийн газарт шилжүүлж,



Зураг №6



Зураг №7

Цагдаагийн газраас АТГ-т шилжүүлсэн байгаа боловч одоог хүртэл тодорхой шийдвэр гараагүй байна.

Б.3 Санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэлийг бүрэн хянаагүй байна

Б.3.1 Зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслээгүй байна

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх” гэж заасан.

Тайлант онд нийт 14 төсөл, арга хэмжээнд нийт 20,212.5 сая төгрөгийн санхүүжилтийг улс, орон нутгийн төсвөөс, 1 төсөл, арга хэмжээний 67.4 сая төгрөгийг БОАЖЯ-аас санхүүжилтийг олгосон байна. /Хүснэгт №2/

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт

/Хүснэгт №2/

№	Төсөл, арга хэмжээ	Тоо	Санхүүжилт /сая төгрөг/		
			Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Нийт олгосон
1	Шинэ хөрөнгө оруулалт	12	7,295.5	6,913.4	14,208.9
2	Шилжих хөрөнгө оруулалт	3	4,739.8	1,263.8	6,003.6
	Дүн	15	12,035.3	8,177.2	20,212.5

Мөн 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээний санхүүжилт болох 96.7 сая төгрөг нь ХХААХҮС-аас 2022 оны 12 сарын 31-ний өдөр шилжүүлснийг, хөрөнгө оруулалтын барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулиар 76.8 тэрбум төгрөгийн 15 төсөл, арга хэмжээнд 29.3 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр батлагдаж, хуульд нэмэлт өөрчлөлт орсноор улсын төсвөөс санхүүжүүлэх дүн 11.1 тэрбум төгрөг хасагдсан байна. Төсвийн тодотголтой холбоотойгоор аймгийн Засаг даргаас улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх 8 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг орон нутгийн төсвөөс шийдвэрлэх тухай хүсэлтийг Сангийн сайдад хүргүүлсэн байна. Тус албан бичгийн хариуд Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль журмын хүрээнд шийдвэрлэх тухай албан бичгийг ирүүлснээр орон нутгийн төсөвт тусган, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулж, 8,177.2 сая төгрөгийг олгосон байна.

Тайлант онд олгосон нийт 20,212.5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлийн баримттай тулгахад дараах зөрчилтэй байна. Үүнд:

- Хатанбулаг сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын 1,999.2 сая төгрөгийн гүйцэтгэлд захиалагчийн хяналтын зардал 33.6 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардал 16.8 сая төгрөгийг суутгаагүй олгосон;
- Говийн бүсийн ахмад настны төрөлжсөн асрамжийн газрын барилгын ажлын 514.6 сая төгрөгийн гүйцэтгэлд захиалагчийн хяналтын зардал 8.2 сая төгрөгийг суутгаагүй илүү шилжүүлсэн;
- Мандах сумын тохижилтын ажлын ирүүлсэн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг 100 хувь буюу 197.3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Зураг төсөвт тусгагдсан ажил одоог хүртэл хийгдээгүй;
- Цэвэр усны нөөцийн сан барих ажлын ирүүлсэн гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг 100 хувь буюу 1,983.5 сая төгрөгийн /улсын төсвөөс 1,700.0 сая төгрөг, орон нутгаас 283.5 сая төгрөг/, санхүүжилтийг олгосон. Зураг төсөвт тусгагдсан ажил одоог хүртэл хийгдэж дуусаагүй;

Ирүүлсэн гүйцэтгэлийг бүрэн хянаагүй, зураг төсөвт тусгагдсан ажлыг дуусаагүй байхад санхүүжилтийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6¹¹, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дэх хэсгийн 4.1.4¹², 4.1.12¹³-т заасныг зөрчиж байна.

Дээрх зөрчилд ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу, чанартай гүйцэтгүүлж, хууль тогтоомжид заасны дагуу хүлээн авах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.3.2 Нэмэлт санхүүжилтийн гэрээ байгуулаагүй байна

Тайлант онд нийт шинээр хэрэгжүүлэх 11, шилжих 3 төсөл, арга хэмжээг гүйцэтгэх ажилд нэмэлт санхүүжилттэй холбоотой гэрээ байгуулагдаагүй байна.

Б.4 Барилгын ажлын үе шатны болон гүйцэтгэлд хяналт тавих ажил хангалтгүй байна

Б.4.1 Захиалагч болон зохиогчийн хяналтыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийгдээгүй байна

Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1-д аймгийн Засаг дарга нь “нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавина” гэж заасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга угсралтын ажлын гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг аймгийн ГХБХБГ-аас хийсэн байна. Хяналтын ажлыг талбарт гүйцэтгэхээс гадна төсөл, арга хэмжээ бүрээр гүйцэтгэгч, зохиогч, захиалагчийг хамруулсан Telegram group үүсгэн тухай бүр мэдээлэл солилцох, үе шатны ажлын явцыг харуулах зураг оруулах зэрэг байнгын холбоотой ажилласан байна. Мөн талбайн журнал буюу барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлд өгсөн үүрэг, тавьсан шаардлага, зөвлөмжийг тэмдэглэж байгаа ч биелэлтийн тэмдэглэлгүй байгаа тухай өгсөн зөвлөмж, шаардлагыг хэрхэн биелүүлж байгаа нь тодорхой бус байна.

Мөн аймгийн ГХБХБГ-аас 197.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мандах сумын тохижилт”-ын ажил нь зураг төсвийн дагуу бүрэн хийгдээгүй байхад “Захиалагчийн барилгын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт”-ийг гарган баталгаажуулсан байна.

Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5-д “барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах” гэж заасан.



¹¹ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;

¹² Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төслийн зураг төсөл болон төсвийн дагуу барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна.

¹³ Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох

Тайлант онд шинэ болон шилжих төсөл, арга хэмжээнд зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх гэрээг зураг төсөв гүйцэтгэсэн байгууллагатай байгуулсан байна. Зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн байдлыг авч үзэхэд талбайн журналд тэмдэглэл хөтлөөгүй, биелэлт оруулаагүй зэрэг байдалтай байна.

Мөн 2022 онд хүлээн авсан төсөл, арга хэмжээ болох 197.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мандах сумын тохижилт”-ын ажлын гэрээнд зохиогчийн хяналтын зардалд 1.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тусгасан. Хяналтыг “Архидеа ХХК” гүйцэтгэж, 4 удаагийн дүгнэлт гаргаж, санхүүжилтийг бүрэн авчээ. Гэтэл хяналтыг хэрэгжүүлсэн гэх ажил бодит байдалд дуусаагүй, зохиогчийн хяналтын нэгдсэн дүгнэлт нь баримтын шаардлага хангаагүй¹⁴, дүгнэлтэд тусгагдсан ажлууд нь цаг хугацааны хувьд хийсэн гэх ажилтайгаа таарахгүй, талбайн журналд тэмдэглэл хөтлөөгүй байна.

Мөн дээрх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч болох “Эко повер лайн инженеринг” ХХК нь гэрээнд заасан хугацаанд ажлыг эхлээгүй, талбайн журнал хөтлөөгүй, графикийн дагуу ажил хийгдсэн мэтээр хуурамч тэмдэглэл хөтөлсөн байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2¹⁵-т заасныг зөрчиж байна.

Иймд “Мандах сумын тохижилт” төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хуулийн байгууллагад шилжүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.4.2 Төсвийн ерөнхийлөн захирагчаас дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан.

Гэтэл аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд хяналт шалгалт хийгдээгүй, дотоод аудитыг чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.

Мөн хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.1¹⁶, 64.1.2¹⁷-т заасны дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хяналт хэрэгжүүлэхээр заасан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын баталсан удирдамжийн дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас сумдад хэрэгжиж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын явцтай танилцсан байна. Харин ажлын гүйцэтгэлтэй холбоотой зөвлөмж өгөөгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх тухай зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.5 Тайлант онд дуусаж, хүлээн авсан төсөл арга хэмжээ нь хууль тогтоомжид заасан шаардлага, нөхцөлийг хангаагүй байна

¹⁴ БХБС-ын 2016 оны 178 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм”

¹⁵ барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

¹⁶ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

¹⁷ тухайн жилийн төсөв, түүний тодотголын төслийг хэлэлцэн батлах, хэрэгжилтэд хяналт тавих, нийтэд мэдээлэх;

Б.5.1 Улсын комисс нь баримт бичгийн бүрдэл нь үнэн зөв байдлыг хангаагүй, зураг төсвийн дагуу хийгдээгүй ажлыг хүлээн авсан байна

Төсвийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5-д барилга байгууламжийг ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг заасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 төсөл, арга хэмжээ /шинэ болон шилжих/ хэрэгжүүлснээс “Мандах сумын тохижилт”-ын ажлыг улсын комиссын УКД 3-28/2022 дугаартай актаар хүлээн авсан байна. Комисс үүрэг даалгаврыг биелэлтийн хуудсаар өгч, биелснээр тэмдэглэсэн байна. Гэтэл аудитаар ажлын гүйцэтгэлийн шалгахад үүрэг даалгаварт өгсөн ажил болон зураг төсөвт тусгагдсан ажлууд хийгдээгүй байна. Мөн зохиогчийн хяналтын дүгнэлт нь холбогдох дүрэмд заасан баримтыг бүрдэл хангаагүй, барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэлийг нөхөж бичсэн бичсэн зэрэг бүрдэлтэй байна.

Төсвийн тухай хуулийн 48 дүгээр 48.8-д дээрх баримт бичгийн үнэн зөвийг захиалагч хариуцна гэж заасан байна.

Иймд дээрх зөрчилтэй асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

Б.5.2 Гэрээний үүргийн биелэлтийг тооцоогүй байна

Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дэх хэсгийн 4.1.30-д төслийн эцсийн санхүүжилт ирүүлэхэд гэрээ дүгнэсэн байх ёстой бөгөөд гэрээ дүгнэх хавсралт маягтыг үйлдэхээр тусгасан.

Гэтэл тайланд хугацаанд хүлээн авсан “Мандах сумын тохижилт”-ын ажлыг хүлээн авахад гэрээ дүгнэсэн баримт бичиг байхгүй, гэрээ хэрхэн дүгнэсэн нь тодорхойгүй байна.

Б.5.3 Тайлант хугацаанд дуусаж, хүлээн авсан төсөл, арга хэмжээг бүртгэлд тусгаагүй байна

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д зааснаар хөрөнгө оруулалт гэдэг нь тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага байна гэж заасан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тайлант онд улсын комисс ажиллаж хүлээн авсан “Мандах сумын тохижилт”-ын ажлыг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгаагүй. Учир нь энэ төсөл, арга хэмжээ нь бүртгэлд тусгах боломжгүй, зураг төсөвт тусгагдсан ажил хийгдээгүй, ашиглагч байгууллага хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

БҮЛЭГ 3: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРИМ АЖИЛ ҮР ДҮНГҮЙ БАЙНА

В.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг хуульд нийцүүлэн төлөвлөөгүй байна

В.1.1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд уялдуулан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөөгүй байна

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 24,423.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл, арга хэмжээг хөгжлийн баримт бичгүүдтэй нийцэж буй эсэхийг судлаагүй, холбогдох тайлан, баримт бичгээр баталгаажуулаагүй, хэрхэн хэлэлцсэн нь тодорхойгүй байна.

Дээрх нөхцөл байдлаас шалтгаалан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдаагүй 8 төсөл, арга хэмжээ батлагдсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хөрөнгө оруулалтын шинж чанаргүй, тухайн шатны төсөв захирагчийн өмчлөлд шилжих боломжгүй, төрийн байгууллагуудаас тавьсан хүсэлтийг шийдвэрлэсэн зэрэг нь эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх нөлөөлөл нь тодорхойгүй, ач холбогдол багатай, хэрэгцээ шаардлагагүй хөрөнгө бэлтгэгдэх эрсдэлтэй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.2.17-д "..., улс болон орон нутгийн төсвийг төлөвлөхдөө 6.10.3¹⁸, 6.10.4¹⁹-т заасан шаардлагыг хангаж улсын болон аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилан боловсруулах" гэж заасан.

Тайлант онд аймгийн хөрөнгө оруулалтаар 67 төсөл, арга хэмжээ, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар 34 төсөл, арга хэмжээ, нийт 101 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталснаас Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдаагүй нийт 1,879.0 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

- Дэлгэрэх сумын ЗДТГ-т ачааны автомашин худалдан авах 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ;
- Замын-Үүд сумын 1-р багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилга барих 806.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ;
- Улаанбадрах сумын төрийн болон төрийн бус байгууллагын үйлчилгээг сайжруулах, тоног төхөөрөмж худалдан авах 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ;
- Сайншанд сумын 2 дугаар багийн нийтийн орон сууцны 111, 115 дугаар байрны дээврийн засварын 65.6 сая төгрөгийн төсөвт, өртөгтэй төсөл, арга хэмжээ;
- Сайншанд сумын 4 дүгээр багийн нутагт 154 дүгээр байрны дээврийн засварын 74.3 сая төгрөгийн төсөв өртөгтэй төсөл, арга хэмжээ;
- Сайншанд сумын 4 дүгээр багт тоглоомын талбай байгуулах ажил 69.5 сая төгрөгийн төсөв өртөгтэй төсөл, арга хэмжээ;
- Сайншанд сумын 8-р багийн 233, 245-р байр /хуучнаар 28, 29-р байр/-ны баруун талаар автозам барих 63.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ;
- Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч ГИХГ-т шаардлагатай техник хэрэгсэл бэлтгэх 700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ;

Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.1.4-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.1.2²⁰-т заасан төслийн саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг

¹⁸ 6.10.3.улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;

¹⁹ 6.10.4.орон нутгийн төсөв нь Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх

²⁰ 3.1.2.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төслүүд нь төсвийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай нь холбогдох нотлох баримтаар тогтоогдсон төсөл байх бөгөөд энэ журамд зааснаар төлөвлөнө.

судалж, холбогдох тайлан болон баримт бичгийг хавсаргасан байна”²¹ гэж заасантай нийцээгүй байна.

Аудитаар дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөж байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

В.1.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн төлөвлөөгүй байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 98,856.9 сая төгрөгийн 147 төсөл, арга хэмжээ батлагдсанаас шинээр хэрэгжих 24,423.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс аймгийн хөрөнгө оруулалтад 22,105.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 төсөл, арга хэмжээ, Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар 2,318.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 34 төсөл, арга хэмжээ, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 57,561.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээнд 23,734.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тус тус баталжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг аймагт 1 удаа, Замын-Үүд суманд 2 удаа тодотгож, 68,458.7 сая төгрөгийн 84 төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэн баталсан байна. /Хүснэгт №3/

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээ /сая төгрөгөөр/

/Хүснэгт №3/

Төсөв захирагч	Анх батлагдсан төсөл, арга хэмжээ			Тодотгосон төсөл, арга хэмжээ			Нэмэгдсэн төсөл, арга хэмжээ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Аймаг	58	28,100.8	14,194.9	125	96,284.3	55,200.7	67	68,183.5	41,005.8
Замын-Үүд сум	21	2,297.6	2,100.0	38	2,572.6	2,293.0	17	275.0	193.0
Нийт	79	30,398.4	16,294.9	163	98,856.9	57,493.7	84	68,458.5	41,198.8

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл 29^{1.1}²², Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.7²³, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол²⁴-д төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүдийг эрэмбэлэн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг бэлтгэхээр заасан байна.

Гэвч аймгийн ХБТХОХ-ээс хууль, тогтоомжид заагдсан шалгуур, нөхцөлийн дагуу хөрөнгө оруулалтыг төлөвлөөгүй, төлөвлөлтийн шатанд хийгдсэн баримт, материал байхгүй байна.

²¹ 3.1.4.2-д “Хөгжлийн урт, дунд, богино хугацааны баримт бичгүүдтэй нийцэж буй байдал”

²² 29^{1.1}-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий төслүүд байна”

²³ 13.1.7.хөдөө аж ахуй, хүнс, импортыг орлох хөрөнгө оруулалтыг нэн тэргүүнд эрэмбэлэх.

²⁴ “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 2.1.2.1-т “төслийн саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх”

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т хөрөнгө оруулалт нь “..., орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлага” гэж заасан.

Гэтэл орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан дараах төсөл, арга хэмжээ нь дээрх хуулийн заалтыг зөрчиж байна. Үүнд:

- “Аймгийн өвс, тэжээлийн нөөц бэлтгэх” ажилд аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 100.0 сая төгрөгийг төсөвлөж, хэрэгжүүлсэн.
- Замын-Үүд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжгүй²⁵ Гадаадын иргэн, харьяатын газарт “Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч ГИХГ-т шаардлагатай техник хэрэгсэл” бэлтгэхэд 700.0 сая төгрөгийн төлөвлөж, хэрэгжүүлсэн.
- Замын-Үүд сумын төсвийн хөрөнгө оруулалтад сургууль, цэцэрлэгүүдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 5 төсөл, арга хэмжээнд нийт 18.1 сая төгрөгийн дэмжлэгийг төлөвлөж, санхүүжүүлсэн. /Хүснэгт №4/

Замын-Үүд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн байгууллагуудад үзүүлсэн дэмжлэгийн жагсаалт /сая төгрөг/

/Хүснэгт №4/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хэрэгжүүлэх хугацаа		Төсөвт өртөг	2022 онд санхүүжих дүн	2022 онд олгосон санхүүжилт
		Эхлэх	Дуусах			
1	Замын-Үүд хүүхдийн 2 дугаар цэцэрлэг /хөргүүр/	2022	2022	3.5	3.5	3.5
2	Замын-Үүд хүүхдийн 3 дугаар цэцэрлэг /дээжийн хөргөгч/	2022	2022	0.5	0.5	0.5
3	Замын-Үүд хүүхдийн 4 дүгээр цэцэрлэг /4 ширэмтэй плитка/	2022	2022	4.9	4.9	4.9
4	Замын-Үүд хүүхдийн 5 дугаар цэцэрлэг /ухаалаг самбар/	2022	2022	3.0	3.0	3.0
5	ЕБ-ын лаборатори 1 дүгээр сургууль /насан туршийн кабинет/	2022	2022	6.2	6.2	6.2
Дүн				18.1	18.1	18.1

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, нийгэмд үзүүлэх нөлөө, ач холбогдол, хэрэгцээ шаардлагыг тооцоолоогүй нь үр ашиггүй зарцуулалт хийгдэх эрсдэлтэй байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3-д²⁶ тухайн шатны Засаг дарга хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг төсвийн төсөлд тусгахдаа санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацааг төсөл нэг бүрээр бүрэн хэмжээгээр тусгахаар заасан.

Гэтэл аймгийн ИТХ-ын тогтоолын төслийг өргөн мэдүүлэхдээ “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалт”-ыг алдаатай төлөвлөж, батлуулсан байна. Үүнд:

²⁵ Төсвийн тухай хуулийн 4.1.24-т “төсвийн хөрөнгө оруулалт” гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

²⁶ 29.3.4-т “санхүүжүүлэх эх үүсвэрээс үл хамааран төсөл нэг бүрийг бүрэн хэмжээгээр тусгах”, 29.3.2-т “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах”

- Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 05/04 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалтын жагсаалтад 2021 онд бүрэн хэрэгжиж дуусаагүй 4,608.2 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээг батлаагүй.
- Аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 04-ний өдрийн 07/03 дугаар тогтоолоор батлагдсан өөрчлөлтөд 2021 онд бүрэн хэрэгжиж дуусаагүй дээрх 33 төсөл, арга хэмжээг 2021 оноос шилжих хөрөнгө оруулалтын 16 төсөл, арга хэмжээтэй давхардуулан баталсан.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорноговь аймагт хэрэгжиж байгаа 57,561.6 сая төгрөгийн 9 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг тусгаагүй.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 9,465.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сургуулийн барилга, 640 суудал /Дорноговь, Замын-Үүд сум/” төсөл, арга хэмжээд орон нутгийн төсвөөс 10,198.1 сая төгрөг буюу батлагдсан төсвөөс 732.2 сая төгрөгийг 2022 онд илүү олгохоор баталсан.

Иймд дээрх алдаа, зөрчлийг таслан зогсоох, албан үүргээ биелүүлээгүй албан хаагчдад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

В.2. Зарим төсөл, арга хэмжээ нь ажил ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байна

В.2.1. Тендерт оролцогчдын чадавхыг бүрэн үнэлээгүйгээс төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрсдэл үүсгэж байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд шинээр хэрэгжих 24,423.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 95 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 22,105.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 67 төсөл, арга хэмжээнээс 63 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 20,268.4 сая төгрөгийн гэрээ байгуулагджээ. Тайлант хугацаанд хэрэгжээгүй 1 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа он дамжин хэрэгжсэн, 2 төсөл, арга хэмжээний сонгон шалгаруулалтад оролцогч ирээгүй учир хүчингүй болсон, 1 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг алдаатай тооцсоноос шалтгаалан хэрэгжүүлээгүй байна.

Мөн Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан 2,318.0 сая төгрөгийн 34 төсөл, арга хэмжээнээс 32 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж 2,189.5 сая төгрөгийн гэрээ байгуулж, 2 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зарлагдаагүй байна. /Хүснэгт №5/

Тайлант онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ

/Хүснэгт №5/

Төсөв захирагч	Худалдан авах ажиллагааны төрөл	Төсөл, арга хэмжээний	Шалгаруулсан	Амжилтгүй болсон Төсөл, арга хэмжээний	
				Тоо	Тайлбар
Аймаг	Нээлттэй тендер шалгаруулалт	37	36	1	Худалдан авах ажиллагаа он дамжсан
	Харьцуулалт арга	21	19	2	Оролцогч ирээгүй
	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам	1	1	-	
	Шууд гэрээ байгуулах	8	7	1	Хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээ
Замын-Үүд сум	Нээлттэй тендер шалгаруулалт	5	5	-	
	Харьцуулалт арга	7	7	-	
	Шууд гэрээ байгуулах	21	19	2	Хэрэгжүүлээгүй төсөл, арга хэмжээ
	Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журам	1	1	-	Худалдан авах ажиллагаа зарлаагүй шууд гараа байгуулсан
Нийт		101	95	6	

Мөн түүнчлэн худалдан авах ажиллагаатай холбоотойгоор нийлүүлсэн хөрөнгө нь ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангахгүй байгаа зөрчил илэрч байна. Үүнд:

ТБОНӨХБАҮХАТ хуулийн 27.1²⁷-д заасан шалгуур нөхцөлийг нэгэн зэрэг хангасан, 16.1.6²⁸-д заасан баримт, бичгээр баталгаажсан нөхцөлд шаардлага хангасан тендер гэж үзэхээр заасан байхад шалгуур хангагдаагүй дараах тендерийг шалгаруулсан байна.

- *Эрдэнэ сумын Төрийн албан хаагчийн 3 айлын орон сууц худалдан авах” 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт “Суман зурхай” ХХК шалгарч 139.5 сая төгрөгөөр гэрээ байгуулж, нийлүүлсэн. Тендерийн баримт бичгийн “Тендер шалгаруулалтын зааварчилгааны 18.6.8”-д тухайн орон сууц нь орон сууцны барилгын стандартыг бүрэн хангасан, Эрдэнэ сумын төвд байрладаг болохыг баримт бичгийг эх хувиас нь хуулбарлан нотолж ирүүлэхээр заасан. Гэтэл тухайн орон сууцыг улсын комисс хүлээн аваагүй, “Суман зурхай” ХХК-ны эзэмшилд албан ёсоор шилжээгүй байхад шалгаруулсан байна.*
- *“Сайншанд, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт иж бүрэн тоноглолтой эмнэлгийн зориулалтын автомашин худалдан авах” 320.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендерт “Эм Жи Эл Ви Ай Пи групп” ХХК шалгарч 320.0 сая төгрөгөөр гэрээ байгуулж, нийлүүлсэн. Тендерийн баримт бичгийн “Тендер шалгаруулалтын зааварчилгааны 18.6”-д ижил төстэй гэрээний туршлагыг 2020, 2021 онуудын аль нэг жилд тухайн төсөвт өртгийн 70 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байхаар шаардсан. Гэтэл тухайн тендерт эмнэлгийн тоноглолтой автомашин худалдан борлуулж байгаагүй, ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл нь хангалтгүй байхад шалгаруулсан байна.*

Захиалагч нь тендерт оролцогчийн мэдвэл зохих шаардлагатай бүх мэдээллийг ТББ-д тусгах²⁹, өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад³⁰ хувааж зохион байгуулж болохоор заасан байхад худалдан авах ажиллагааг багцад хувааж өрсөлдөөнийг дэмжээгүй, мэдээллийг бүрэн тусгаагүйгээс шалтгаалж нийлүүлсэн бараа, материал нь ашиглалтын шаардлага хангахааргүй, хүлээн авах тоо хэмжээ нь тодорхойгүй нөхцөл байдлыг үүсгэсэн зөрчил илэрч байна.

1. *“Хүүхдийн зуслангийн тавилга, тоног төхөөрөмж” нийлүүлэх 500.0 сая төгрөгийн төсөвт, өртөгтэй төсөл, арга хэмжээний ТББ-т нийлүүлэх бараа, ажил үйлчилгээний тоо, хэмжээг тодорхой тусгагдаагүй нь байна.*
2. *Замын-Үүд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн “Хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлын зураг, төсөв” хийлгэх нийт 43.6 сая төгрөгийн төсөвт*

²⁷ 27.1.1.энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасныг үндэслэн захиалагчийн тогтоосон чадавхийн шаардлага; 27.1.2.техникийн тодорхойлолт; 27.1.3.тендерийн баримт бичигт заасан бусад нөхцөл, шаардлага.

²⁸ 16.1.6.нийлүүлэх барааны загвар, тодорхойлолт, эсхүл гэрэл зураг, тэдгээрийн үнэн болохыг гэрчилсэн баримт бичиг;

²⁹ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 19.2-д “Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана”

³⁰ 8.6-д “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар нь хэд хэдэн багцад хувааж тендер шалгаруулалт явуулж болно”

өртөгтэй ажлыг багцад хувааж “Архитект” ХХК-тай шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ын 8.5³¹, 8.7.1³²-д заасныг зөрчсөн байна.

3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа тухайн ААНБ-ын санхүү, хүний нөөц, техник хэрэгслийн чадамжийг бүрэн үнэлдэггүйгээс 6 хүртэлх төсөл, арга хэмжээг 1 ААНБ гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажилласан байна. Энэ нь төсөл, арга хэмжээ хугацаандаа хэрэгжихгүй байх, чанаргүй гүйцэтгэх зэрэг эрсдэлийг үүсгэж байна. /Хүснэгт №6/

**Дорноговь аймагт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг
гүйцэтгэж байгаа ААНБ-ын мэдээлэл /2020-2022 он/**

/Хүснэгт № 6/

Тоо	Гүйцэтгэгчийн		Гүйцэтгэж байгаа ТАХ-ны тоо	2022 онд шалгарсан ТАХ-ны тоо	Хэрэгжиж дууссан ТАХ- ний тоо	Хэрэгжиж дуусаагүй ТАХ-ний тоо
	Нэр	Регистрийн дугаар				
1	Альянстрейд ХХК	5781657	3	3	2	1
2	Дэлгэр баясах зам ХХК	3314529	9	6	6	3
3	Егү говь ХХК ярих	3320871	4	4	1	3
4	Мандах наран сүлжээ ХХК	3316769	2	2	0	2
5	Нью ворлд инженеринг энд констракшн ХХК	5968151	4	4	3	1
6	Төгс-Өнөд ХХК	3319024	4	2	3	1
7	Чандмань-Илч ОНӨХХК	2771551	8	2	5	3
8	Элит конкрет ХХК	6148581	3	1	1	2
9	Энержи парагон ХХК	5217016	5	4	3	2

4. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн “Халдвартын эмнэлгийн тавилга, тоног төхөөрөмж” бэлтгэх 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын эхний тендер амжилтгүй болж дахин 2 багцад хуваан зарласан. Гэвч захиалагчаас тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 4 өдрийн өмнө ТББ-т ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 22.3³³ дахь заалтыг зөрчсөн байна.

Дээрх зөрчилд холбогдох албан тушаалтанд хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг таслах зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

В.2.2. Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэл үр дүнгүй байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс дараах төсөл, арга хэмжээнүүд нь хэрэглэгч, ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцээгүй, ажлын тоо хэмжээ, чанарт хүрээгүй бараа, ажил үйлчилгээг хүлээн авсан байна. Үүнд:

Аймгийн хөрөнгө оруулалт

1. “Өргөн сумын Ахмадын өргөөний барилга барих” - /358.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ ажил нь Барилгын тухай хуулийн 14.1.2³⁴-д заагдсан барилга байгууламжийн норм, норматив, ашиглалтын шаардлага хангахгүй байна. Тухайлбал: Барилгын гадна хаяавч барилгын үндсэн хийцээс 2 см хүртэл хөндийрсөн, сан болон дулааны үүслийн өрөө нь өвөлдөө цан цохиж хаалганд гажилт үүссэн, барилга дотор хэсгээрээ мөөгөнцөртсөн, шалны паркет хооронд зай үүссэн, том өрөөний гол хэсэгт шалны үндсэн цутгалт товойж дээш түрсэн, хаалганы дотор, гадна талдаа 3 см хүртэл хагарал үүссэн, үүд

³¹ 8.5-д “энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно”

³² 8.7.1-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгоно”

³³ 22.3-д “Тендер оролцогч тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын таваас доошгүй хоногийн өмнө захиалагчаас авах хүсэлтийг бичгээр гаргаж болно”

³⁴ 14.1.2.барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг хангасан байх;

хэсгийн баруун зүүн жигүүрийн өрөөний дотор хаалганы дээд хэсгээр цууралт үүссэн. Шалны зарим хэсэгт паркет шалны хүрээнд далдлагдаагүй 1 см хүртэл дутсан, дээврийн төмөр салхинд хөдөлгөөн их орсон, бэхэлгээ, битүүмж муу хийгдсэнээс дусаал гоожиж таазанд эвдрэл гарсан байна. Дээрх нөхцөл байдлууд үүссэн байхад гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах хуульд³⁵ заасан үүргээ хэрэгжүүлээгүй байна. /Зураг №8/



Зураг №8

Өргөний ахмадын өргөөний барилгад үүссэн эвдрэл, гэмтэл

2. “Сайншанд, Замын-Үүд сумын нэгдсэн эмнэлэгт иж бүрэн тоноглолтой эмнэлгийн зориулалтын автомашин худалдан авах” - /320.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ автомашин нь ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцэхгүй, тендерт шалгараагүй автомашиныг захиалагч хүлээн авсан. Тухайлбал “Эм жи эл ви ай пи групп” ХХК нь “Nissan Urvan E26” маркийн автомашин нийлүүлэхээр шалгарсан боловч “Ford Tranzit CLW5037...” маркийн автомашиныг нийлүүлсэн. Тухайн автомашины өвчтөн тээвэрлэх хэсэгт зориулалтын пар байхгүй байгаагаас хүйтний улиралд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх боломжгүй байна. /Зураг №9/



Зураг №9

3. “Эрдэнэ сумын Төрийн албан хаагчийн 3 айлын орон сууц худалдан авах” - /139.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ орон сууц нь улсын комисс хүлээж аваагүй, нийлүүлсэн “Суман зурхай” ХХК-ны эзэмшилд албан ёсоор шилжээгүй, орон сууцны стандарт шаардлагыг хангахааргүй байхад барилгыг хүлээн авсан байна. /Зураг №10/


³⁵ 14.4. Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ.



Зураг № 10

4. “Хамарын хийдийн захиргаанд усны машин худалдан авах” - /51.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ автомашин нь ТББ-д захиалагчийн шаардсан чанар байдалд хүрээгүй, үйлдвэрийн угсралтгүй, кабины доторлогоогүй, усны хаалт, крант нь эвдэрсэн, торхны дотор талд зэврэлтээс хамгаалсан түрхлэг, будаггүй, дулаалгаагүй, сэрүүний улиралд ашиглах боломжгүй байна. /Зураг №11/

Зураг №11




5. “Улаанбадрах сумын төрийн болон төрийн бус байгууллагын үйлчилгээг сайжруулах, тоног төхөөрөмж худалдан авах” - /48.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ ажилд дэлгэц нь гэмтсэн, нугас нь хугарсан 2ш зөөврийн компьютер хүлээн авч ашиглагч байгууллагад нийлүүлсэн. Уг асуудлыг бэлтгэн нийлүүлэгч мэдэгдсэн ч арга хэмжээ аваагүй, ашиглах боломжгүй байна.
6. “Зүүнбаян багийн Эрүүл мэндийн төвд яаралтай түргэн тусламжийн УАЗ фургон автомашин худалдан” - /50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ төсөл, арга хэмжээ нь Зүүнбаян багийн Эрүүл мэндийн төвд хэрэгжээгүй Сайншанд сумын ЗДТГ-т Toyota Hiace маркийн авто машин худалдан авч үр дүнгүй зарцуулалт хийсэн байна.
7. “Хүүхдийн зуслангийн тавилга, тоног төхөөрөмж” худалдан авах - /498.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ ажлыг хэрэгжүүлэхдээ өмнөх оны хөрөнгө оруулалтаар хийгдэж, хүлээн авсан сагсан бөмбөгийн шит, гар бөмбөгийн шон, хөл бөмбөгийн хаалга зэргийг ажлын тоо, хэмжээнд оруулсан байна. Мөн нийлүүлсэн зарим бараа, бүтээгдэхүүн нь ашиглах боломжгүй, ТББ-т заагдсан чанарын шаардлагад хүрэхгүй байхад авсан. Тухайлбал: Хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх ном, гадна талбайн цагаан хоолой, камер, гар станц зэрэг нь ашиглалтын шаардлага хангахгүй байна. /Зураг №12-13/

Зураг №12



Өмнөх оны аудитаар авсан зурган дээр хөл бөмбөгийн хаалга, сагсны шийд, гар бөмбөгийн шон зэрэг нь хийгдсэн байна

Зураг №13



Хүүхдийн зуслангийн тоног, төхөөрөмж нийлүүлэх ажлын тоо хэмжээнд зарлагдаж хүлээн авсан хөрөнгө

8. “Халдвартын эмнэлгийн тавилга, тоног төхөөрөмж” худалдан авах - /98.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ ажлын зарим бараа материал нь нийлүүлэгдээгүй, ТББ-т тусгагдсан чанар, шаардлагад хүрээгүй байхад хүлээн авсан байна. Тухайлбал: Сувилагчийн пост нь ТББ-т модон материалтай 2ш байхаар заагдсан гэвч ашиглахад хүндрэлтэй, зөөвөрлөх боломжгүй 1ш шахмал чулуун пост нийлүүлэгдсэн, мөн эсгий гудас, хөвөнтэй хөнжил нийлүүлэхээр шалгарсан байхад сентопон дотортой хөнжил, гудас нийлүүлсэн нь эмнэлгийн хэрэгцээ шаардлагад нийцэхээргүй байна. /Зураг№14/



Сувилагчийн пост

Сентопон материалтай хөнжил, гудас тус бүр 50 ширхэг нийлүүлэгдсэн

9. “Тохижилт Сайншанд хот тохижилтын газарт хогийн автомашин худалдан авах /дэгээтэй 6 ширхэг/” - / 314.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ автомашинууд нь хүнд даац авах зориулалтгүй зогсоолын дугуйтай нийлүүлэгдсэнээс шалтгаалж хог тээвэрлэх явцад хагарч, бууддаг шаардлага хангахгүй байна. /Зураг №15/



Зураг №15

10. “Айраг сумын 35 айлын орон сууцны гадна хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоол, явган хүний зам байгуулах” - /64.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ төсөл, арга хэмжээ нь хувийн хэвшлийг бизнесийг дэмжсэн хөрөнгө оруулалт байна. Тухайлбал: “Элит конкрет” ХХК-ны Айраг суманд 2021 шинээр ашиглалтад оруулсан орон сууцны гаднах нийтийн эзэмшлийн бүсэд тоглоомын талбай, явган хүний зам, авто зогсоол бариулахад орон нутгийн төсвөөс санхүүжилт олгосон байна.

Дээрх зөрчлийг арилгах, таслан зогсоох тухай албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

Мөн Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 33.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайншанд сумын автозамд нийтийн тээврийн автобусны зогсоол байгуулах, 106.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сайншанд сумын төвийн автозамд тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, хучлагын засвар”-ын ажил нь чанаргүй хийгдсэн тул 2022 оны 5 сард дахин хийлгүүлэхээр улсын комиссын акт үйлдсэн боловч одоог хүртэл хийгдээгүй байна. /Зураг №16-17/



Сайншанд суманд шинээр хийсэн автобусны зогсоол



Сайншанд сумын төвийн автозамд тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч, хучлагын засварын ажил

Иймд дээрх зөрчилтэй асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Замын-Үүд сумын хөрөнгө оруулалт

1. Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн “Мод усалгааны авто машин худалдан авах” - /49.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй/ автомашин нь ТББ-д захиалагчийн шаардсан чанар байдалд хүрээгүй, үйлдвэрийн угсралтгүй, яндан болон торхны бэхэлгээ нь ханзарсан, усны хаалт, крант нь эвдэрсэн, торх нь эргэн тойрондоо замасктай, хэд хэдэн газарт шүүрэлт үүссэн, торхны дотор талд зэврэлтээс хамгаалсан түрхлэг, будаггүй, хянах самбар ажилладаггүй, торх болон усны шугам хоолой нь дундаа ризенин холболттой сэрүүний улиралд хөлдсөн нөхцөлд галаар гэсгээх боломжгүй байна. /Зураг №18/

Зураг №18



Хуучин яндан угсарч нийлүүлсэн байдал



Ашиглагч байгууллагаас хийсэн нэмэлт бэхэлгээ



Усны хаалт, крантнаас ус байнга алддаг



Торх эргэн тойрондоо замасктай, ус шүүрч алддаг



Бэхэлгээ холбоосгүй шууд их биетэй холбосон

2. “Үрслэгээний хөрсөн бортгоо худалдан авах” 49.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил нь гэрээнд заагдсаны дагуу хийгдээгүй, гүйцэтгэгчид 24.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож гэрээг цуцалсан боловч үрслэгээний хэдэн бортгоо хүлээн авсан нь тодорхойгүй, акт үйлдээгүй байна. Мөн хүлээн авсан бортгонд мод ургаагүй үр ашиггүй зарцуулалт хийгдсэн байна. /Зураг №19/



Үйлдвэрлэгдсэн бортгоо



Тариалалт хийсэн талбай

Дээрх зөрчлийг арилгах, таслан зогсоох тухай албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэв.

В.2.3. Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслээгүй байна

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлсэн нийт 138 төсөл, арга хэмжээнд 30,819.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, нийт 78.4 хувийн гүйцэтгэлтэй байна. /Хүснэгт №7/

Дорноговь аймагт хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл

/Хүснэгт №7/

Төсөв захирагч	Төлөвлөлт	Төсөл, арга хэмжээний тоо	2022 онд санхүүжүүлэх дүн	Олгосон санхүүжилт	Гүйцэтгэлийн хувь
Аймаг	Шинэ	62	18,795.0	11,939.3	63.5
	Шилжих	34	9,460.5	8,557.1	90.5
	Улсын төсвийн хөрөнгө оруулалтад олгосон	8	22,734.5	8,177.1	36.0
	Дүн	104	50,990.0	28,673.5	63.3
Замын-Үүд сум	Шинэ	34	2,293.0	2,145.5	93.6
	Дүн	34	2,293.0	2,145.5	93.6
Нийт дүн		138	53,283.0	30,819.0	78.4

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6³⁶, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дэх хэсгийн 4.1.4³⁷, 4.1.12³⁸-т заасныг зөрчиж байна. Гэтэл орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг бүрэн хянаагүй, батлагдсан төсөвт тусгагдаагүй болон дуусаагүй ажилд санхүүжилтийг олгосон нь Тухайлбал:

- “Айраг сумын ЗДТГ-ын барилгын их засвар”-ын ажлын дээврийн засварт төлөвлөгдсөн 28.4 сая төгрөгийн төсвөөр үүдний хэсэгт шилэн пистүүл хийж гүйцэтгүүлсэн байна. Ажлыг өөрчлөн гүйцэтгүүлсэн боловч бодит өртгийн тооцоололгүй, санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- Замын-Үүд сумын Онцгой байдлын хэлтсийн гадна хашааны засварын ажлын гэрээг иргэн С.Сүхтөмөртэй гэрээ байгуулж, 11.8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна. Гэтэл гэрээнд тусгагдсан ажил одоог хүртэл хийгдээгүй байна.
- Замын-Үүд сумын “Нийтийн орон сууцны дээврийн засварын ажил /130, 131, 132, 134, 135а, 136, 137, 143-р байрууд” төсөл, арга хэмжээний 4.5 сая төгрөгийн магадалшгүй ажлын зардлыг холбогдох ажлын тайланг үндэслээгүй байна.
- Замын-Үүд сумын хөрөнгө оруулалтаар “Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч ГИХГ-т шаардлагатай техник хэрэгсэл” бэлтгэх төсөл, арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотын “Гадаадын иргэн, харьяатын газрын конторын А байрны гадна фасад засвар”-ын ажил гүйцэтгэх гэрээг 2022.12.16 өдөр “Тэнгэрийн модон багана” ХХК-тай 334.6 сая төгрөгөөр хийсэн. Гэрээнд урьдчилгаа санхүүжилтийг гэрээний үнийн дүнгийн 30 хувиар олгохоор заасан байна. Гэтэл тухайн гэрээнд заагдсан ажил хийгдэж эхлээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Дээрх зөрчлүүдэд холбогдох албан тушаалтанд хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байх тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

В.2.4. Эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилтэд хяналт тавиагүй байна

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэж заасан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба 2022 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.

³⁶ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх;

³⁷ Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төслийн зураг төсөл болон төсвийн дагуу барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна.

³⁸ Төслийн санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох

В.2.5. Төсөл, арга хэмжээг хүлээн авах үйл ажиллагаа нь хууль, журмын дагуу зохион байгуулагдаагүй байна

Аймгийн ГХБХБГ-тай байгуулсан “Захиалагчийн хяналт гүйцэтгэх гэрээ”-ний 3.5-д “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг холбогдох дүрэм журмын дагуу хариуцан зохион байгуулж, хөрөнгийн ашиглагч байгууллагын санхүүгийн бүртгэлд тусгуулна” гэж тусгасан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 16,868.2 сая төгрөгийн төсөл, арга хэмжээнээс 6,283.8 сая төгрөгийн 49 төсөл, арга хэмжээг хөрөнгийг бүртгэлд тусгаагүй байна. Үүнд:

- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан 15,096.4 сая төгрөгийн 80 төсөл, арга хэмжээнээс 5,447.5 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллага бүртгэлд тусгуулаагүй байна.
- Замын-Үүд сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж дууссан 1,771.8 сая төгрөгийн 29 төсөл, арга хэмжээнээс 836.3 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээг ашиглагч байгууллагын бүртгэл тусгуулаагүй байна.

Дээрх зөрчилд хөрөнгө оруулалтын ажлыг зохих дүрэм, журмын дагуу бүртгэлд тусгуулж төрийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах тухай албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох баримт, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан зарим төсөл, арга хэмжээ Монгол Улсын болон аймгийн дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, улсын нэгдсэн бодлоготой уялдаагүй байна.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр батлагдсан төсөл, арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төлөвлөөгүй байна.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 51,031.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулсан ч ТББ-г бүрэн үнэлээгүй байна.
- Барилга угсралтын ажилд захиалагч болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг зураг төсвийн дагуу хийгдээгүй, ажлын гүйцэтгэл дуусаагүй байхад хүлээн авч, 2,180.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 818.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж, санхүүжүүлсэн байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээнд хүрээгүй төсөл, арга хэмжээг хүлээн авч 2,091.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтаар чанарын шаардлага хангаагүй, ашиглагч байгууллагын хэрэгцээ шаардлага хангахгүй машин, тоног төхөөрөмж, хөрөнгө нийлүүлэгдсэн байна.
- Нийт 6,283.8 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд бүрэн тусгаагүй байна.
- ТЕЗ болон ИТХ-аас төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна.

Аудитаар нийт 169,174,8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 85,368.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох тухай албан шаардлага, 82,066.0 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв

Холбогдох байгууллагын санал:



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Нутгийн удирдлагын ордон, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас: 7052 2533, Факс: (976) 7052 2530,
Цахим шуудан: zdtg@dornogovi.gov.mn,
Цахим хуудас: www.dornogovi.gov.mn

2023.04.20 № 01/465
танай _____-ны № _____-т

**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА**

“Улс орон нутгийн төсвийн хөрөнгө
оруулалтын 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр
дүн” сэдэвт аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа.

Аудитын тайлантай холбоотой саналгүй
болно.

ЗАСАГ ДАРГА



О.БАТЖАРГАЛ

D/2022/toot-A5
44 6230444



ДОРНОГОВЬ АЙМАГ
ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

118 дугаар байшин, Залуучуудын гудамж-1, 3 дугаар баг,
Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 3998

Цахим хуудас: dornogovi@gazar.gov.mn

2023.04.20 № 232

танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитыг хийж гүйцэтгэсэн тайлангийн төсөлд тус газраас саналгүй болно.

ДАРГА

Ц.ОЮУНСАЙХАН

4420000448

D://2023/Alban bichig/A5.doc



ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР

Соёмбо цогцолборын 306 тоот, Алтанговийн гудамж 2,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103
Утас/факс: (705) 2-00-04

Цахим шуудан: dornogobionug@gmail.com

2023.04.20 № 96
танай _____-ны № _____-т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Т.ГАН-ӨЛЗИЙ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-нд үндэслэн хэрэгжүүлсэн "Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн" сэдэвт аудитыг хийж гүйцэтгэсэн тайлантай холбоотойгоор дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Эрдэнэ сумын Төрийн албан хаагчийн 3 айлын орон сууц худалдан авах 140 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад "Суман зурхай" ХХК-н санал болгосон 139,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 айлын орон сууц нь эзэмшигч "Сизу" ХХК болон "Суман зурхай" ХХК-н хооронд хийсэн худалдах худалдан авах гэрээ ирүүлсэн. Мөн тус худалдан авах 3 айлын орон сууц нь улсын комисс ажилласан болно.
2. Хүүхдийн зуслангийн тавилга тоног төхөөрөмж нийлүүлэх 500 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний ажил үйлчилгээний тоо, хэмжээ нь захиалагчаас баталж ирүүлсэн тоо хэмжээний дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан болно.
3. Халдвартын эмнэлгийн тавилга тоног төхөөрөмж бэлтгэх 100 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2 дахь удаагаа зарлахад захиалагчаас 2022 оны 06 сарын 06-нд ирүүлсэн тодруулга оруулах тухай албан бичгийг үнэлгээний хороо хэлэлцээд тендер нээх хугацаа 2022 оны 06 сарын 10-ны өдөр байсан тул тендер нээхээс өмнө 5 хоногт тодруулга оруулах боломжтой гэсэн төрийн болон орон, нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22.3-т заалтыг зөрчөөгүй гэж үзэн тодруулгыг цахим системд оруулсан болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Т.МӨНХ-ЭРДЭНЭ



Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:

Аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 96 тоот албан бичгээр ирүүлсэн саналд дараах тайлбарыг гаргаж байна. Үүнд:

Санал 1: Эрдэнэ сумын Төрийн албан хаагчийн 3 айлын орон сууц худалдан авах 140 сая төгрөгийн төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад “Суман зурхай” ХХК-н санал болгосон 139,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 айлын орон сууц нь эзэмшигч “Сизу” ХХК болон “Суман зурхай” ХХК-н хооронд хийсэн худалдах худалдан авах гэрээ ирүүлсэн. Мөн тус худалдан авах 3 айлын орон сууц нь улсын комисс ажилласан болно.

Саналд өгөх тайлбар 1: Тендер шалгаруулалтын зааварчилгааны 18.6.8”-д тухайн орон сууц нь орон сууцны барилгын стандартыг бүрэн хангасан, Эрдэнэ сумын төвд байрладаг болохыг баримт бичгийг эх хувиас нь хуулбарлан нотолж ирүүлэхээр заасан. Гэтэл тухайн орон сууцыг улсын комисс хүлээн аваагүй, “Суман зурхай” ХХК-ны эзэмшилд албан ёсоор шилжээгүй, орон сууцны стандарт шаардлагыг хангахгүй тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Санал 2: Хүүхдийн зуслангийн тавилга тоног төхөөрөмж нийлүүлэх 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний ажил үйлчилгээний тоо. хэмжээ нь захиалагчаас баталж ирүүлсэн тоо хэмжээний дагуу тендерийн баримт бичгийг боловсруулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан болно.

Саналд өгөх тайлбар 2: ТБОНӨХБАҮХАТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана” гэж заасан байгаа тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Санал 3: Халдвартын эмнэлгийн тавилга тоног төхөөрөмж бэлтгэх 100 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2 дахь удаагаа зарлахад захиалагчаас 2022 оны 06 сарын 06-нд ирүүлсэн тодруулга оруулах тухай албан бичгийг үнэлгээний хороо хэлэлцээд тендер нээх хугацаа 2022 оны 06 сарын 10-ны өдөр байсан тул тендер нээхээс өмнө 5 хоногт тодруулга албан бичгийг үнэлгээний хороо хэлэлцээд тендер нээх хугацаа 2022 оны 06 сарын 10-ны өдөр байсан тул тендер нээхээс өмнө 5 хоногт тодруулга оруулах боломжтой гэсэн төрийн болон орон, нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 22.3-т заалтыг зөрчөөгүй гэж үзэн тодруулгыг цахим системд оруулсан болно.

Саналд өгөх тайлбар 3: ТБОНӨХБАҮХАТХ-ийн 19 дүгээр зүйлийн 19.2-т Тендерийн баримт бичигт тендерт оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендерт оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана” гэж заасан байгаа тул тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт, нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА О.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөх. /Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл/
2. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг төлөвлөх. /Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл/
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлэх. /Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл/
4. Өмнөх оны аудитаар дахин хийгдэхээр гэрээ байгуулсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллах. /Тайлангийн Б.2.1, В.2.2 дахь хэсэгт дурдсан болно/
5. Барилга угсралтын ажилд захиалагчийн болон зохиогчийн хяналтаар хэрэгжүүлэх ажлын гэрээг дүгнэж, санхүүжилтийг олгох.

АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:

ГҮЙЦЭТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Л.РАВДАНДОРЖ

АУДИТОР

Б.УРАНБИЛЭГ

ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

У.ОЮУНТҮЛХҮҮР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 11/12

Сайншанд сум

**Гүйцэтгэлийн аудитын тайлан
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.2, 18.10, 2021 оны А/69 дүгээр тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, 2023 оны А/04 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн “Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлагуудыг хавсралтаар баталсугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлэхийг Засаг даргад зөвлөсүгэй.

4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Замын-Үүд сумын Засаг дарга, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газарт тус тус хүргүүлсүгэй.

5. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Оюунтүлхүүр)-т даалгасугай.



Т.ГАН-ӨЛЗИЙ

010010030